

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Өвөрхангай аймгийн Шүүхийн шинжилгээний албаны 2022 оны
санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн
аудит

Аудитын код: ӨВА-2023/124/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn

Өвөрхангай аймаг,
Арвайхээр сум

2023 он

Тэргүүлэх аудитор: О.Батжаргал

Утас: 70323253 Цахим хаяг: Batjargalo@audit.gov.mn

Аудитын менежер: Д.Гансүх

Утас: 70323833 Цахим хаяг: gansukh.audit@gmail.com

Ахлах аудитор: Б.Эрдэнэцэцэг

Утас: 70323108 Цахим хаяг: Erdenetsetsegb@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Нэг. Хараат бус аудиторын дүгнэлт



ӨВӨРХАНГАЙ АНМАЛ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн удирдлагын ордон, П.Г.Бидэнгийн түүдэм,
5 дугаар баг, Арвайхээр сум, Өвөрхангай аймаг, 02173
Тусгай Факс: (076) 7032 3253
Цахим дуудан: ovorkhang.audit.gov.mn
Цахим хуудал: www.audit.mn

ШҮҮХИЙН ШИНЖИЛГЭЭНИЙ АЛБАНЫ ДАРГА Э.ЦЭДЭВСҮРЭН ТАНАА

2022.07.22 № 30
Танай _____-ны № _____-д

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Шүүхийн шинжилгээний албаны 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Шүүхийн шинжилгээний албаны 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон зүйл

Тайлант онд Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэн. Тухайн байгууллагын хувьд тус хуулийн 6 дугаар зүйлийн 6.5.9 болон 8 дугаар зүйлийн 8.2 дахь зүйлүүдэд зааснаар тээврийн хэрэгсэл, дүрэмт хувцасны талаарх хязгаарлалтад хамрагдаагүй.

Орон нутгийн төсвөөс дэмжлэг үзүүлж, аймгийн Засаг даргын нөөцөөс нэн шаардлагатай санхүүжилт болох 4.2 сая төгрөгийг олгосон байна. Жилийн эцсээр 1.4 сая төгрөгийг улсын төсөвт татан төвлөрүүлсэн.

Аудитын гол асуудлууд

Бидний мэргэжлийн шийдлийн дагуу аудитын гол асуудлууд гэж тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн их нөлөөтэй асуудлуудыг үздэг. Санхүүгийн тайланд хийсэн аудитынхаа хүрээнд эдгээр асуудлуудыг нэгтгэсэн байдлаар авч үзсэн ба дүгнэлтээ гаргахдаа эдгээр асуудлуудад тус бүрчлэн дүгнэлт гаргаагүй болно.

01-03-070

Тус байгууллагад ШШҮХ-с 11.0 сая төгрөгийн автомашин, 13.9 сая төгрөгийн тоног төхөөрөмжийг балансаас балансад шилжүүлэн бүртгэжээ. Мөн 6.9 төгрөгийн элэгдэлийг хулилтлагдсан элэгдэл дансанд бүртгэжээ.

Бусад мэдээлэл

Удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдүүдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



О.БАТЖАРГАЛ

Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

		/сая төгрөгөөр/	
	Үзүүлэлт	2021.12.31	2022.12.31
Санхүүгийн байдлын тайлан			
	Эргэлтийн хөрөнгийн дүн	2.4	2.6
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	144.4	145.2
	Нийт хөрөнгийн дүн	146.8	147.7
	Нийт өр төлбөрийн дүн	0	
	Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	146.8	147.7
	Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	146.8	147.7
	Үйл ажиллагааны орлогын дүн	268.6	266.6
	Үйл ажиллагааны зардлын дүн	266.4	265.7
	Үйл ажиллагааны үр дүн	2.2	0.9
	Үйл ажиллагааны бус үр дүн		
	Үйл ажиллагааны нийт үр дүн	2.2	0.9
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан			
	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	144.6	146.8
	Тайлант оны үр дүн	2.2	0.9
	Эцсийн үлдэгдэл	146.8	147.7
Мөнгөн гүйлгээний тайлан			
	Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	268.6	248.6
	Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	268.6	246.1
	Үйл ажиллагааны ЦМГ	0	
	Хөрөнгө оруулалтын ЦМГ		2.5
	Санхүүгийн ажиллагааны ЦМГ		
	Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	0	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0	0
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0	0
Төсвийн гүйцэтгэлийн тайлан			
	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	244.1	268.6
	Урсгал зардал	244.1	268.6
	Хөрөнгийн зардал		
	Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр		
	Улсын төсвөөс санхүүжих	240.8	268.6
	Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас	3.3	3.3

Гурав. Аудитын илрүүлэлт:

Аудитаар нийт 2 зөрчил¹ илэрч 2 зөвлөмж өгсөн.

1. Шатахууны зардалтай холбоотой асуудал

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Илрүүлэлт:

Батлагдсан маягтаар эд хариуцагчийн тайланг гаргаагүй, үлдэгдлээр тусгасан шатахууны тооллогын баримтжуулалт хангалтгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Шатахууны тайланг сар бүр гаргаж, анхан шатны баримтын бүрдүүлэлтэд хяналт тавьж ажиллах. Зөвлөмжийн биелэлтийг албан бичгээр нотлох баримтын хамт Төрийн аудитын газрын FAS системд оруулж илгээх

2. Эмийн зардалтай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Бэлтгэн нийлүүлэгч байгууллагын зарлагын падааныг үндэслэж эм, хэрэгслийг орлого аваагүй, анхан шатны баримтын бүрдүүлэлт хангалтгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Эмийн тайлангийн анхан шатны баримтын бүрдүүлэлтэд хяналт тавьж ажиллах. Зөвлөмжийн биелэлтийг албан бичгээр нотлох баримтын хамт Төрийн аудитын газрын FAS системд оруулж илгээх

Дөрөв. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл:

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/сая төгрөгөөр/												
Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Дүн												

Санхүүгийн тайлангийн аудитаар залруулга гараагүй.

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн										
Эд хариуцагчийн тайланг батлагдсан маягтаар сар бүр гаргаагүй.	1						1					
Эмийн тайлантай холбоотой баримтын бүрдүүлэлт хангалтгүй	1						1					
Дүн	2						2					

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/сая төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Дүн								
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Дүн								
Нийт дүн								

Нийцлийн аудитын асуудлаар Шилэн дансны тухай болон бусад хууль тогтоомжтой холбоотой алдаа, зөрчил гараагүй.

Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1			1			
2	Төсөл, хөтөлбөр								
3	ЗГТС								
4	ТТЗ								
5	ТЕЗ								
	НИЙТ								

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

